

## ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зорилго нь: Хууль сахиулахын их сургуулийн /цаашид “Их сургууль” гэх/ магистр, докторын сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хууль сахиулахын их сургуулийн “Магистр, докторын сургалтын журам” нь /цаашид “сургалтын журам” гэх/ Дээд боловсролын тухай хууль, Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам (БСШУ-ны сайдын 2007 оны “Дүрэм, журам батлах тухай” 187 тоот тушаал), “Хууль сахиулахын их сургуулийн дүрэм”-д үндэслэнэ.

1.3. Магистр, докторын сургалт нь Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, олон улсын нийтлэг жишигт нийцүүлж, шинжлэх ухаан, технологийн дэвшилд үндэслэн гэмт явдал, цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээ, гамшиг судлалын чиглэлээр суралцагсдад эрдэм шинжилгээ, сургалт, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудад мэргэжлийн өндөр түвшинд үүрэг гүйцэтгэх, судалгааны ажил эрхлэх, бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал, ес зүйг эзэмшсэн магистр, докторын зэрэгтэй мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд оршино.

### Хоёр. Сургалтын орчин, шаардлага

#### 2.1. Удирдлага:

2.1.1. Их сургуулийн хэмжээнд магистр, докторын сургалтыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт болон шинээр нээх хаах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг тооцох, Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулах, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн томилох, шинэчлэх, зөвлөлийг өргөтгөхөд шаардагдах мэдээлэл болон суралцагч, төгсөгчидтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг бүхий Магистр, докторын сургалтын албатай байна.

2.1.2. Магистр, докторын сургалтын алба нь Магистр, докторын сургалтын үйл ажиллагааг Их сургуулийн дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн профессорын баг (цаашид “профессорын баг” гэх), бүрэлдэхүүн сургуультай хамтран хэрэгжүүлнэ.

2.1.3. Магистр, докторын сургалтын албаны дарга нь эрдэм шинжилгээ, сургалтын ажлын 3-аас доошгүй жилийн туршлагатай, доктор (Ph.D) болон түүнээс дээш зэрэгтэй байна.

2.1.4. Магистр, докторын сургалтыг профессорын баг, бүрэлдэхүүн сургууль, төв, тэнхимд түшиглэн зохион байгуулна.

2.1.5. Профессорын баг нь тэргүүлэх профессор, тэнхимийн зөвлөх профессор, клиникийн профессор, бүрэлдэхүүн сургуулийн захирал, бусад байгууллагын эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхэлдэг эрдэмтэдээс бүрдэнэ.

2.1.6. Профессорын багийн бүрэлдэхүүнийг Эрдмийн дэд зөвлөлийн саналыг үндэслэн их сургуулийн захирлын тушаалаар томилно.

2.1.7. Профессорын багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа тэнхимийн зөвлөх профессор, клиникийн профессор, бусад байгууллагын эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхэлдэг эрдэмтдийг гэрээ байгуулан ажиллуулна.

2.2. Багш:

2.2.1. Магистр, докторын сургалтад хичээл заадаг багш нь тухайн чиглэлээр доктор (Ph.D) болон түүнээс дээш зэрэгтэй байна.

2.2.2. Магистрын сургалтын төлөвлөгөөнд заагдсан ерөнхий суурь ухааны болон зарим мэргэжлийн суурь хичээлийг докторант багш зааж болох бөгөөд энэ талаар тусгайлан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.2.3. Магистр, докторын сургалтад оролцдог профессор, багш нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байна.

2.2.4. Магистр, докторын сургалтад хичээл заадаг багшийн багц цагийн үнэлгээг тухайн түвшний сургалтын онцлог, хөдөлмөр зарцуулалт, мэргэжлийн ур чадвар, эрдмийн зэрэг, цолд дүйцүүлэн, бусад их сургуулийн жишигт нийцүүлэн тус сургуулийн “Профессор багшийн ажлыг багц цагаар үнэлэх журам”-аар тогтооно.

2.3. Магистрант, докторантын удирдагч:

2.3.1. Их сургуулийн Захирлын тушаалаар магистрант, докторантын элссэн улиралд багтаан, суралцагч нэг бүрээр профессорын багт харъяалуулж эрдэм шинжилгээний ажлын удирдагч /цаашид “Удирдагч” гэх/-ийг томилно.

2.3.2. Магистрант, докторантын удирдагч нь доктор (Ph.D) болон түүнээс дээш зэрэгтэй байна.

2.3.3. Магистрын судалгааны ажлын сэдвийг тухайн хичээлийн жилийн эхний улиралд багтаан профессорын баг, эрдмийн дэд зөвлөлийн хурлаар, докторын диссертацийн сэдвийг суралцагчийн элссэн хичээлийн жилд багтааж, Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2.3.4. Магистрант, докторант сэдэв батлуулах үндэслэлийг дараах бүтцээр бичнэ.

а/ Сэдвийн судлагдсан байдал;

б/ Сэдвийн талаар гарсан бүтээл, гол үр дүн;

в/ Сэдвийн хүрээнд шийдэгдээгүй асуудал;

г/ Сэдвийн хүрээнд судалгааны арга зүй;

2.3.5. Удирдагч профессор нь магистрант, докторантын судалгааны ажлын сэдэв, судалгааны ажлын төлөвлөгөөг чиглүүлэн тогтоож, биелэлтийг нь хянаж, судалгаа явуулах болон магистрын ажил, диссертаци бичих явцад тодорхой хуваариар мэргэжлийн зөвлөгөө өгч, ажлын агуулгыг хэсэг бүрээр болон бүхэлд нь дүгнэх, удирдсан магистрын ажил, диссертацийг хамгаалалтад оруулах тодорхойлолт гаргах, эрдэм шинжилгээ, судалгааны семинарт судалгааны ажлынхаа үр дүнг илтгэн хэлэлцүүлж байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Удирдагч суралцагчийн судалгааны ажлын талаар үнэн зөв тодорхойлолт гаргаж, түүнийг хариуцна.

2.3.6. Магистрын судалгааны ажил сэдвийн онцлогоос хамаарч тухайн профессорын багийн тэргүүлэх профессорын саналыг үндэслэн судалгааны ажлын зөвлөхийг томилж болно.

2.3.7. Удирдагч хичээлийн нэг жилд 4-өөс илүүгүй магистрант, 2-оос илүүгүй докторантын судалгааны ажил удирдана. Шинжлэх ухааны докторын хувьд танхимын

сургалтын ачаалал, судалгааны сэдвийг харгалзан 3 докторант, 5-аас илүүгүй магистрант, удирдагчаар ажиллахыг зөвшөөрч болно.

2.3.8. Гадны байгууллагын эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг ажилтныг удирдагчаар томилж болно. Гадны байгууллагын нэг удирдагчид 1 докторант, 2-оос илүүгүй магистрантын ажил удирдах зөвшөөрөл олгоно.

2.3.9. Удирдагч магистрант, докторанттай зохих шаардлагын түвшинд ажиллаж байгаа эсэхэд Магистр, докторын сургалтын алба, профессорын баг хяналт тавьж, шаардлага хангахгүй байгаа удирдагчийг өөрчлөх саналаа Эрдмийн дэд зөвлөлд тавьж, зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Захирлын тушаалаар удирдагчийг өөрчлөн томилж болно.

2.4. Номын сан, мэдээллийн бааз:

2.4.1. Магистр, докторын сургалт явуулж буй чиглэлээр мэргэжлийн сэтгүүл захиалах, чиглэл бүрт хүрэлцэхүйц хэмжээний ном, сурах бичиг, нэг сэдэвт зохиол, интернэт ашиглах боломжоор хангах, мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цуврал, магистрын ажил, докторын диссертацийн сантай байх шаардлагыг Их сургуулийн номын сан хангаж ажиллана.

2.4.2. Номын сан нь магистрант, докторант нарт тусгайлан үйлчилдэг уншлагын танхим, интернет мэдээллийн төвтэй байх ба түүнд Магистр, докторын сургалтын алба хяналт тавина.

2.4.3. Суралцагч суралцах хугацаандаа “Хууль сахиулахын их сургуулийн дүрэм”, “ХСИС-ийн дотоод журам”, “Номын сангийн дүрэм”-ийн хүрээнд номын сан, компьютерийн лаборатори, интернетээр үйлчлүүлэх эрхтэй.

2.4.4. МДСА магистрант докторантын эрдэм шинжилгээ судалгааны ажлын явц үр дүнг хэвлэн нийтлэх “Эрдмийн бичиг” цувралыг улирал бүр эмхэтгэн хэвлүүлнэ.

2.4.5. Бүрэлдэхүүн сургуулиуд улиралд 1-ээс доошгүй удаа хэвлэгддэг өөрийн эрдэм шинжилгээний сэтгүүлтэй байна.

### **Гурав. Сургалтын үйл ажиллагаа**

3.1. Магистрант, докторант элсүүлэх :

3.1.1. Мэргэжлийн профессорын багууд магистрант, докторант элсүүлэх мэргэжлийн чиглэл, элсэх хүний тооны талаарх саналаа МДСА-нд ирүүлэх бөгөөд ирсэн саналыг Их сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан комисс БШУЯ-наас олгосон сургалтын чиглэл, хөтөлбөрт нийцүүлэн хичээлийн жилд 1 удаа (9-р сарын 20-ны дотор) зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд их сургуулийн захирлын тушаалаар хугацаа харгалзахгүй элсэлтийг зохион байгуулж болно.

3.1.2. Магистр, докторын сургалтын алба элсэгчдийн баримт бичгийн бүрдүүлэлт, тэдгээрийн үнэн зөвийг шалгаж, бүртгэх ажил зохион байгуулна.

3.1.3. Магистрын сургалтанд элсэгч тухайн мэргэжлээр бакалаврын, докторын сургалтанд элсэгч тухайн мэргэжлээр магистрын зэрэгтэй байна.

3.1.4. Нууцын зэрэглэлд хамаарах сэдвийг нийтэд зарлахгүйгээр албаны журмаар мэдээллэж, элсэлт авч болно.

3.1.5. Магистрын сургалтад элсэхээр хүсэлт гаргасан хүний бакалаврын зэргийн дипломд бичигдсэн хос мэргэжилд эрх зүй хамаарч байвал мэргэжил, мэргэшүүлэх хичээлийн багтаамж нь 80 кредитээс багагүй байна.

3.1.6. Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгч дараах материал бүрдүүлж, товлосон хугацаанд элсэлтийн комисст ирүүлнэ. Үүнд:

- Өргөдөл;
- Биеийн байцаалт (төрийн албан хаагчийн 1-р маягтаар);
- Иргэний үнэмлэх (баталгаажуулсан хуулбар);
- Бакалаврын диплом, хавсралт (баталгаажуулсан хуулбар); голч 3.0 (80)-аас дээш
- Суралцагчийн ажлыг зохицуулан, түр чөлөөлөхийг зөвшөөрсөн харьяа байгууллагын албан бичиг;
- 3x4 хэмжээтэй гэрэл зураг 2% ;
- Элсэлтийн хураамж төлсөн баримт ;

Докторантурт элсэгч дараах материал нэмж ирүүлнэ.

- Магистрын диплом, хавсралт (баталгаажуулсан хуулбар); голч 3.3 (85%)-аас дээш
- Бүтээлийн жагсаалт;
- Судалгааны ажлын агуулга, чиглэл, зорилгын талаар бичсэн реферат (6-8 хуудас).

3.1.7. Элсэхийг хүсэгчид нь бакалавр, магистрын зэргийн боловсрол эзэмшсэнээс хойш төрийн албанд 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байна.

3.1.8. Хууль сахиулахын их сургуулийг бакалаврын зэрэгтэй төгсөгчийг Улсын шалгалтын нэгдсэн комиссоос магистрын сургалтад, магистрын зэрэгтэй төгсөгчийг Хамгаалуулах зөвлөлөөс докторын сургалтад суралцах зөвлөмж, урилга өгсөн бол тухайн жилд элсэлтийн шалгалтгүйгээр суралцуулж болно. Урилгаар элсэгч сургалтыг шалтгаангүй орхисон бол сургуулиас хасна.

3.1.9. Монгол Улсын хууль, тогтоомжын дагуу суралцах хүсэлтээ албан ёсоор тавьсан гадаадын иргэдийг магистр, докторын сургалтад суралцуулах асуудлыг БШУ-ны яамны гадаадын иргэдийг суралцуулах журмын дагуу элсүүлэн суралцуулж болно.

3.1.10. Гадаадын иргэн-элсэгч нь ерөнхий шаардлагаас гадна монгол хэлийг зохих түвшинд эзэмшсэн байх шаардлага хангасан байна. Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу суралцуулахад гэрээ хэлэлцээрт заасан нөхцлийг баримтална.

3.1.11. Гадаадын иргэдийн сургалтын төлбөр, бүрдүүлэх нэмэлт материалын жагсаалтыг тусгайлан тогтооно.

3.1.12. Магистр, докторын сургалт өдөр, эчнээ, экстернат хэлбэртэй байна.

3.1.13. Дараах болзол хангасан элсэгчийг экстернат хэлбэрээр суралцуулж болно.

Үүнд:

а) Эрдэм шинжилгээ, сургалт, практик ажлын 8-аас доошгүй жил, магистрын сургалтад экстернат хэлбэрээр суралцахыг хүсэгчдэд 5-аас доошгүй жилийн туршлагатай байна.

б) Докторын сургалтад экстернат хэлбэрээр суралцахыг хүсэгч эрдэм шинжилгээ, судалгааны 5-аас доошгүй бүтээлтэй, үүний 3-оос доошгүй /өгүүлэл/ нь хянан магадлагаа хийдэг улсын болон гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн байх, үр дүн нь диссертацид орохгүй бүтээлүүд нь мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлүүдийн багц цагтай дүйцүүлэн тооцох боломжтой, магистрын сургалтад экстернат хэлбэрээр суралцахыг хүсэгч 3-оос доошгүй бүтээлтэй, үүний 2-оос доошгүй /өгүүлэл/ нь хянан магадлагаа хийдэг улсын болон гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн байх, үр дүн нь магистрын ажилд орохгүй бүтээлүүд нь мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлүүдийн багц цагтай дүйцүүлэн тооцох боломжтой байна.

в) Магистрын ажил, докторын диссертацийн 50-аас дээш хувийг хангахуйц бүтээл бичиж бэлэн болгосон.

г) Экстернатаар суралцахыг хүссэн элсэгчийн эрдэм шинжилгээний ажлын агуулга, чанар, үр дүнгийн талаар тухайн чиглэлийн 3-аас доошгүй эрдэмтний дүгнэлт бүхий тодорхойлолт гаргана.

3.1.14. Элсэхийг хүсэгчид бүртгүүлэхдээ хураамж төлнө.

3.2. Элсэлтийн шалгалт:

3.2.1. Элсэгчдээс уралдаант шалгалт мэргэжил, гадаад хэлний мэдлэгээр авна.

3.2.2. Мэргэжлийн шалгалт нийт үнэлгээний 60 хувь, гадаад хэл 40 хувийг эзлэх ба босго оноо нь тус бүрийн 50 хувьтай тэнцэнэ.

3.2.3. Мэргэжлийн шалгалтыг тест хэлбэрээр авч, 0-100 оноогоор дүгнэнэ. Докторын сургалтад элсэгчийн рефератад өгөх үнэлгээ нь мэргэжлийн шалгалтын 30 хувьтай тэнцэнэ.

3.2.4. Гадаад хэлний шалгалтыг магистрын сургалтад элсэгчдээс цаашид суралцах чиглэлээс хамаарч англи болон бусад хэлээр, докторын сургалтад элсэгчдээс англи, орос хэл хосолсон байдлаар тус тус бичгээр авч, дүгнэнэ.

3.2.5. Шалгалтын тестийг сургалтын чиглэл тус бүрээр боловсруулах бөгөөд тестийн нууцлалыг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга хариуцна.

3.2.6. Шалгалтын сорилын асуултад хариулахдаа бусдын дэмжлэг авах, хувилбар солих, тусгай бэлтгэсэн зүйл, ном зохиол ашиглах, бусдад туслах, тухайн элсэгч шалгалтад өөр хүн оруулах зэрэг хэлбэрээр хуурч мэхлэхийг оролдсон элсэгчийг шалгалтын журам зөрчсөнд тооцож, шалгалтаас хасна.

3.2.7. Шалгалтын материалыг элсэлтийн комисс засч, тухай бүрт нь дүнг нийтэд зарлана.

3.2.8. Шалгалтад хамгийн өндөр оноо авсан шалгуулагчдаас эхлэн, буурах дарааллаар (суралцах чиглэл тус бүрээр) жагсаалт үйлдэн байр эзлүүлнэ. Шалгалтын нийт оноо тэнцсэн тохиолдолд мэргэжлийн шалгалтын оноо, бакалавр, магистрын дипломын голч дүнг үндэслэж шийдвэрлэнэ.

3.2.9. Элсэлтийн шалгалтын комиссын дүгнэлт-санал, сургалтын төлбөр төлсөн байдлыг үндэслэн, магистр, докторын сургалтад суралцуулах тухай Их сургуулийн Захирлын тушаал гарсанаар тухайн хүнийг зохих түвшний сургалтад элссэнд тооцно.

3.2.10. Элсэлтийн шалгалтад амжилтгүй дүн үзүүлсэн болон шалгалтад ороогүй хүнд бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

3.3. Хичээлийн жил, улирал, сургалтын хугацаа:

3.3.1. Магистрын сургалтын ердийн хугацаа өдрөөр суралцахад 1.5 жил, эчнээгээр суралцахад 2.5 жил, экстернат 1 жил байна. Докторын сургалтын хугацаа өдрөөр суралцахад 3 жил, эчнээ суралцахад 4 жил, экстернат 2 жил байна.

3.3.2. Сургалтын хичээлийн жил 15-аас доошгүй долоо хоног бүхий 2 улирлаас тогтоно.

3.3.3. Суралцагчийн 1 улирлын ачаалал 9-12 багц цаг байна /эчнээ хэлбэрээр суралцагчийн нэг улирлын ачаалал нэг улиралд 6 багц цагаас ихгүй байна/

3.3.4. Магистр, докторын сургалтын албаны дарга суралцагчийн авьяас чадвар, мэргэжлийн бэлтгэлийг харгалзан, тэнхимийн саналыг үндэслэн нэг улиралд 3 хүртэл багц цагийн хичээлийг нэмж үзэхийг зөвшөөрч болно.

3.3.5. Магистрын сургалт хичээлийн улирал жил бүрийн 10,11, 3,5 сарын эхний долоо хоногийн Даваа гарагт, докторын сургалт 11, 12, 4, 5 сарын эхний долоо хоногийн Даваа гарагт эхэлнэ.

3.3.6. Магистрант, докторант /цаашид “Суралцагч” гэх/ нар элссэнээс хойш 1 сарын дотор сургалтын гэрээ магистр, докторын сургалт хариуцсан нэгжийн даргатай байгуулж мөрдөнө.

3.4. Мэдлэг, чадварыг үнэлэх:

3.4.1. Суралцагчдийн мэдлэг, чадварыг "ХСИС-ийн суралцагчдийн мэдлэг, чадварыг үнэлэх журам"-аар тогтооно.

3.4.2. Суралцагч нь улирлын эцэст дууссан хичээлээр хуваарийн дагуу шалгалт өгөх ба хичээлийн дүн “С”-ээс доошгүй байна.

3.4.3. Үнэлгээ нь энэ түвшинд хүрээгүй бол зохих бэлтгэлийг хангасны дараа зөвхөн тухайн улирлын нэг хичээлийн шалгалт төлбөртэй дахин өгч болно.

3.5. Агуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр:

3.5.1. Магистрын сургалт 30, докторын сургалт 60 багц цагаас тус тус доошгүй байна.

3.5.2. Сургалтын төлөвлөгөөг Эрдмийн зөвлөл, БШУ-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Их сургуулийн Захирал батална. Салбар дундын болон мэргэжил дундын магистр, докторын сургалтыг эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн явуулж болно.

3.5.3. Магистрын сургалтын төлөвлөгөө дараах бүтэцтэй байна.

д/д	Хичээлийн нэр	Багц цаг
1	Судалгааны арга зүй	3
2	Гадаад хэл	3
3	Мэргэжлийн хичээл	10
4	Мэргэшүүлэх хичээл	15
5	Магистрын ажил	6
Бүгд 32-37 кредит		

3.5.4. Докторын сургалтын төлөвлөгөө дараах бүтэцтэй.

д/д	Хичээлийн нэр	Багц цаг
1	Эрдэм шинжилгээний арга зүй	3
2	Гадаад хэл	3
3	Мэргэжлийн хичээл	6
4	Мэргэшүүлэх хичээл	30
5	Эрдэм шинжилгээний ажил	6
6	Диссертаци	12
Бүгд 60 кредит		

3.5.5. Сургалтын багц цагийн задаргаа

Багц цаг	Нийт	өдөр	
		танхимд	Бие даалт
1 багц цаг	48 цаг	16	32
2 багц цаг	96 цаг	32	64
3 багц цаг	144 цаг	48	96

3.5.6. Суралцагч хичээлийн I улиралд багтаан сургалтын төлөвлөгөөг үндэслэн, удирдагчтайгаа зөвлөн, сэдвээ сонгож, сургалт-судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулж харьяалах профессорын багаар хянуулан, магистр, докторын сургалтын албаар батлуулж мөрдөнө.

3.5.7. Сургалт-судалгааны ажлын төлөвлөгөөнд ерөнхий болон мэргэжлийн хичээл судлах, мэргэшүүлэх хичээлийн хэлбэр, агуулгыг хэрхэн тогтоож хангах, судалгааны сэдэв, түүний бүтцийг боловсруулан, батлуулах, бүлэг, зүйл бичих, удирдагчаар хянуулах, зөвлөмжийн дагуу засвар хийх, судалгаа-туршилт явуулах, эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлэх, өгүүлэл бичиж, нийтлүүлэх хугацааг хичээлийн жилийн улирал, сараар тодорхой тусгана.

3.5.8. Сургалтын төлөвлөгөөнд дэх хичээл бүрийн хөтөлбөр нь уг хичээлийн зорилго, багтаамж, судлагдахуун, ашиглах ном зохиолыг заавал багтаана.

3.5.9. Магистр, докторын сургалтад хичээл заах багш нь хичээлийн хөтөлбөр боловсруулж, профессорын багаар хэлэлцүүлэн, МДСА-ны даргаар батлуулна.

3.6. Магистрын сургалт:

3.6.1. Магистрын сургалтын гадаад хэлний хичээлийн хөтөлбөрийг эрдэм шинжилгээний бүтээл, нийтлэл уншиж орчуулах, судалгааны ажилд хэрэглэх, үзэл бодлоо илэрхийлсэн эссе, өгүүлэл бичих чадвар олгох зорилгоор боловсруулна.

3.6.2. Судалгааны арга зүй хичээлээр судалгааны орчин үеийн арга ашиглах, үр дүнг тооцож боловсруулах, эрдэм шинжилгээний бүтээл судлах, бичих, нийтлэх, илтгэх арга зүй эзэмшүүлнэ.

3.6.3. Мэргэжлийн заавал судлах хичээл нь тухайн салбарын бакалаврын түвшний сургалтаас ахисан түвшинд судлаач хүний эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон байна.

3.6.4. Мэргэшүүлэх буюу сонгон судлах хичээл нь суралцагчийн судалгааны сэдэвтэй шууд холбоотой мэдлэг эзэмшсэн байхад чиглэгднэ. Мэргэжлийн чиглэлээс хамаарч, команд-штабын болон хээрийн сургуульд оролцохыг мэргэшүүлэх хичээлд тооцож болно.

3.6.5. Магистрын ажлын багц цагийг магистрантын бичсэн судалгааны ажил нь шаардлага бүрэн хангасан гэж удирдагч тодорхойлж, сэдвийн талаар эрдэм шинжилгээний хурал, сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн байдлыг МДСА баталгаажуулж магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд магистрын ажлыг хамгаалснаар тооцно.

3.7. Докторын сургалт:

3.7.1. Докторын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрдэм шинжилгээний арга зүй хичээл хэд хэдэн хичээлээс бүрдэх бөгөөд агуулгад нь судалгааны арга зүй, философи социологийн асуудлыг заавал тусгана.

3.7.2. Гадаад хэлний хичээлийн хэлбэрийг докторант өөрөө сонгох ба хөтөлбөрийн агуулгыг магистрын сургалтаас ахисан түвшинд боловсруулна.

3.7.3. Мэргэшүүлэх хичээл нь докторантын диссертацийн судалгааны чиглэлд хамаарах бөгөөд агуулга нь дараах хэсгээс тогтоно. Үүнд:

а/ Танхимын 12-оос доошгүй багц цагийн сургалт;

б/ Судалгааны чиглэлээр 6-аас доошгүй эрдэм шинжилгээний илтгэл боловсруулан, Их сургуулийн профессорын багийн семинарт хэлэлцүүлж, 18 хүртэл кредит хангах;

Тайлбар: Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, яам, агентлагийн хэмжээнд болон улс, олон улсын шинж чанартай эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийг хэрхэн үнэлэн тооцох асуудлыг судалгааны семинарын журамд нарийвчлан тусгана. Мэргэжлийн чиглэлээс хамаарч, команд-штабын болон хээрийн сургуульд оролцохыг мэргэшүүлэх хичээлд тооцож болно.

3.7.4. Докторантын сургалтын төлөвлөгөөн дэх эрдэм шинжилгээний ажил нь тухайн сэдвээр бичиж, хянан магадлагаа бүхий мэргэжлийн сэтгүүл болон гадаадын сэтгүүлд хэвлүүлсэн 2-оос цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүллээр тооцогдоно.

3.7.5. Докторын диссертацийн багц цагийг докторантын бичсэн диссертаци шаардлага бүрэн хангасан гэж тэргүүлэгч профессор болон удирдагч тодорхойлж, сэдвийн талаар эрдэм шинжилгээний хурал, сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн байдлыг МДСА, профессорын баг баталгаажуулж, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд диссертаци хамгаалснаар тооцно.

3.8. Гадаад хэлний болон нэгдсэн шалгалт:

3.8.1. Докторант хичээлээр цуглуулах нийт багц цагийг хангасны дараа гадаад хэлний болон мэргэжил, мэргэших чиглэлээр мэдлэг, диссертаци бичихэд шаардлагатай бие даасан судалгаа явуулах чадварыг нотлох зорилго бүхий нэгдсэн шалгалт тус тус өгнө.

Шалгалтыг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна.

3.8.3. Гадаад хэлний шалгалтыг суралцагчийн судалсан хичээлээр авч, “С”-гээс дээш үнэлгээтэй тохиолдолд хангалттайд тооцно.

3.8.4. Энэ үнэлгээг хангаж чадаагүй суралцагч зохих сургалтад хамрагдсаны дараа дахин шалгалт өгнө. Энэ нь сургалтын хугацаа, багтаамж, төлбөрт тооцогдохгүй.

### **Дөрөв. Магистрын ажил хамгаалах**

4.1. Магистрын ажил нь тухайн шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлсэн судалгаа, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээг онол, арга зүйн өндөр түвшинд гүйцэтгэж, тодорхой сэдвээр бодит үндэслэл, онол, практикийн дүгнэлт зэрэг үр дүнд хүрсэн эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл байх шаардлага хангасан байна.

4.2. Магистрын ажлын хамгаалалтын өмнөх /урьдчилсан хамгаалалт/ хэлэлцүүлгийг профессорын багийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинараар хийнэ.

4.3. Өргөтгөсөн семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны тэмдэглэлийн хамт магистр, докторын сургалтын албанд хүргүүлнэ. Семинар /урьдчилсан хамгаалалт/-ын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ.

4.4. Магистрын ажлыг Их суруулийн дэргэдэх магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалуулна.

4.5. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг Их сургуулийн Захирлын тушаалаар байгуулна.

### **Тав. Докторын диссертаци хамгаалах**

5.1. Докторын диссертаци нь харгалзах салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн, улс орны нийгэм, эдийн засагт холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй (арга, аргачлалын дагуу нотлон) шийдсэн, урьд өмнө хийгдсэн шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр хандаж, шинэлэг талыг нээн



харуулсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг, мэдээлэл, үндэслэл, онол, практикийн ач холбогдолтой дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлага хангасан байна.

5.2. Докторын диссертацийг тухайн чиглэлийн эрдэмтдийн өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй профессорын багийн семинараар хэлэлцүүлнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хэлбэрээр явуулна. Хэлэлцэн, дэмжсэн семинарын тэмдэглэл, шийдвэр нь диссертацийг докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хүргүүлэх үндэслэл болно.

5.3. Диссертацид тавигдах шаардлага нь БСШУ-ны сайдын 2007 оны 187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 16-д заасан шаардлагатай нийцсэн байна.

5.4. Докторын диссертацийг докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална.

5.5. Диссертацийг монгол хэлээр бичнэ. Диссертацийн товч танилцуулгыг орос, англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацид хавсаргана. Горилогчийн хүсэлт, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх олонхийн зөвшөөрснөөр диссертацийг орос, англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг орос, англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд диссертацийн товч танилцуулга, хураангуйг монгол хэлээр бичнэ.

5.6. Магистрын ажил, докторын диссертацид тавигдах эрдэм шинжилгээний эх бичвэрийн стандартыг Их сургуулийн Захирлын тушаалаар батална.

5.7. Докторын диссертациа хамгаалж чадаагүй бол 3 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтанд орох хүсэлтээ докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргад гаргаж шийдвэрлүүлнэ.

### **Зургаа. Докторантын сургалт, судалгааны ажилд үнэлгээ, дүгнэлт өгөх, аттестатчилах, судалгааны үр дүнг хэвлүүлэх**

6.1. Докторантын сургалт, судалгааны ажилд дараах субъект дор дурьдсан хугацаанд үнэлгээ дүгнэлт өгнө. Үүнд:

6.1.1. Суралцах хугацаанд харъяалах профессорын баг, удирдагч нь зөвлөмж, хяналт шалгалтаар тогтмол ханган ажиллаж, жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор докторантын сургалт судалгааны ажлын талаарх тодорхойлолтыг /үнэлгээ, дүгнэлтийг/ хурлын тэмдэглэлийн хамт магистр, докторын сургалтын албанд ирүүлж, Магистр, докторын сургалтын алба докторант бүрээр дүгнэлт гарна.

6.1.2. Тухайн жилийн XI сард Их сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан комисс докторантын сургалт, судалгааны ажлыг:

а/ танхимын сургалт;

б/ нэгдсэн шалгалт;

в/ профессорын багийн семинараар илтгэл хэлэлцүүлэн багц цаг хангасан байдал;

г/ хянан магадалгаа бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байдал;

д/ диссертацийн бичилт;

е/ удирдагчийн үнэлгээ гэсэн үзүүлэлтээр аттестатчилалд хамруулан, 0-100 буюу F-A үнэлгээгээр тус бүрийг нь шалгаж, нэгдсэн үнэлгээ-дүгнэлт гаргана.

6.1.3. Аттестатчилалд докторант “С”, “D” үнэлгээтэй шалгагдвал түүнд 3-10 сарын хугацаатай үүрэг, даалгавар өгч, дахин дүгнэлт гаргана.

6.2. Докторант судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу диссертацийн сэдвийн хүрээнд бичсэн 2-оос доошгүй эрдэм шинжилгээний өгүүллийг хянан магадлагаа бүхий

мэргэжлийн сэтгүүл, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн байна (Магистрантын хувьд нэг өгүүлэл байна).

### **Долоо. Анги дэвшүүлэх, сургалтаас чөлөөлөх, сургалтаас хасах**

7.1. Хичээлийн тухайн улирлын сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн суралцагчийг профессорын багийн саналыг үндэслэн дараагийн улирлын сургалтад дэвшүүлэн суралцуулна.

7.2. Хүндэтгэх шалтгааны улмаас суралцах боломжгүй болж, Их сургуулийн Захиралд хандан чөлөө хүссэн суралцагчид нэг жилийн чөлөө олгоно. Докторантад энэ чөлөөг дахин нэг удаа олгож болно.

7.3. Хичээлийн 1 дүгээр улирлаас хойшхи хугацаанд дараагийн шатны сургалтын төлбөрөө төлөх боломжгүй суралцагч нэг удаа жилийн чөлөө авч болно.

7.4. Суралцагчийг дараах үндэслэлээр хасна. Үүнд:

а/ Сургалтын төлбөр барагдуулаагүй;

б/ 40-с дээш цагийн хичээл тасалсан;

в/ Нэг улирлын 2 шалгалт амжилтгүй өгсөн ба дахин шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн;

г/ Төрийн тусгай албанаас хасагдсан нь тухайн магистрант, докторантын судалгааны ажилд харшлахаар бол.

### **Найм. Магистрын ажил, докторын диссертаци хүлээлгэн өгөх**

8.1. Магистр, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга хамгаалалтын дараа дараах материал бүрдүүлж, магистр, докторын сургалтын албанд ирүүлнэ. Эдгээр материалыг дипломын хуулбарын хамт сургуулийн архивт хадгална. Үүнд:

а) Дэлгэрэнгүй анкет (1 маягт) ;

б) Хамгаалуулах зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, тогтоол;

в) Удирдагчийн тодорхойлолт;

г) Албан ёсны шүүмж;

д) Зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн, удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан магистрын ажил, докторын диссертаци, түүний CD бичлэг 2 хувь;

е) Тооцоо хийсэн тойрох хуудас;

8.2. Диссертацийн хувийг Үндэсний төв номын сан, Шинжлэх ухаан технологийн номын сан, ХСИС-ийн номын санд, магистрын ажлыг тухайн сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

8.3. Нууцын асуудалд хамаарах диссертаци, магистрын ажлыг Их сургуулийн нууцын номын санд хүлээлгэн өгнө.

### **Ес. Төгсөлт, шилжилт хөдөлгөөн**

9.1. Магистрант, докторант сургалтын багц цагийг бүрэн хангасан бол ХСИС-ийн магистр, докторын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно.

9.2. Магистрын сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 3 жил, докторантын сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 5 жил хүртэл хугацаанд хүчинтэй. Энэ хугацаанд магистрын ажил, докторын диссертаци бичиж, хамгаалах эрхтэй.

9.3. Өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй профессорын багийн семинараар диссертацаа хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй докторантад ажлаа цэгцлэн, 1.5 жилийн дотор дахин хэлэлцүүлэх эрх олгоно.

9.4. Гадаад, дотоодын бусад их дээд сургуульд амжилттай суралцаж байсан магистрант, докторантыг профессорын баг, МДСА-ны саналыг үндэслэн магистр, докторын сургалтад их сургуулийн захирлын тушаалаар шилжүүлэн суралцуулж болно.

9.5. Шилжин ирсэн суралцагчийн хичээлийн багц цагийг бусад сургуульд судалсан хичээлээс дүйцүүлэн тооцож болно.

#### **Арав. Доктор, магистрын зэрэг олгох шийдвэр гаргах**

10.1. Магистрын болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн тогтоолыг үндэслэн магистр, докторын зэрэг олгох тухай Их сургуулийн Захирлын тушаалаар диплом бичиж олгоно.

#### **Арван нэг. Сургалтын төлбөр**

11.1. Магистр, докторын сургалтын төлбөрийг жил бүр захирлын зөвлөлийн хурлын саналыг үндэслэн, Их сургуулийн захирлын тушаалаар шинэчлэн тогтооно.

11.2. Суралцагч сургуулиас сурлага, сахилгаар хасагдсан тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй. Захиалагч сургалтын төлбөрийг төлсөн тохиолдолд зардлыг буцаан төлөх бол түүнийг суралцагч өөрөө хариуцна.

11.3. Суралцагч сургуулиас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тохиолдолд тухайн суралцсан хугацааны зардлыг суутган тооцно.

11.4. Магистрын ажил, докторын диссертаци хамгаалахтай холбоотой зардлыг сургалтын төлбөрт оруулахгүй ба зөвхөн хамгаалалт явагдсан нөхцөлд магистрын ажлын 6, диссертацийн 12 багц цагтай тэнцэх хэмжээний төлбөрийг жинхэнэ хамгаалалтаас нэг сарын өмнө төлнө.

11.5. Магистрант, докторантын удирдагч, албан ёсны шүүмжлэгч, хамгаалуулах зөвлөлийн хуралд таслах эрхтэйгээр ажилласан гишүүдийн ажлын хөлсийг хамгаалалтын зардлаас тооцож олгоно.

#### **Арван хоёр. Бусад зүйл**

12.1. Суралцагчийн суралцах хугацаанд магистр, докторын сургалтын журам өөрчлөгдсөн тохиолдолд суралцагчийн эрх ашиг хөндөгдөхөөр байвал түүнд аль ашигтай зохицуулалтыг мөрдлөг болгоно.

-----oO-----